



1992 – 2022



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ (PROGRES) ТӨСӨЛ

Мэдээллийн хуудас



2023 оны 2-р улирал



“ХАМТДАА ЭРДЭНЭТЭД ХӨГЖЬЕ-2023” ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ

2023 оны 6-р сарын 15-17-ны өдрүүдэд Орхон аймагт “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье-2023” эдийн засгийн форум амжилттай зохион байгуулагдлаа. Эдийн засгийн форум нь хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг ба гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих, хөрөнгө оруулагчдыг татах зорилготой юм.

Гурван өдөр үргэлжилсэн арга хэмжээ нь Эдийн засгийн форум, IT чуулган, ERDENET MLC E-sport-ийн тэмцээн, “Смарт Эрдэнэт Экспо” гэсэн дөрвөн хэсэгтэй байлаа. Форумын гурав дахь өдөр нь Facebook AR filter бүтээх, дижитал Арт сургалт, лево кодинг, электроник кодингийн сургалтуудыг өдрийн турш үнэ төлбөргүй зохион байгуулав.

“Хамтдаа Эрдэнэтэд хөгжье-2023” эдийн засгийн форумд гадна дотнын олон зочид төлөөлөгчид, бизнес эрхлэгчид оролцож, илтгэл мэдээлэл солилцсон юм. Тухайлбал, БНСУ-ын шилдэг технологийн компаниуд оролцож, аж үйлдвэрийн цогцолборын кластер байгуулахаар яриа хэлэлцээ эхлүүлсэн байна. Мөн Орхон аймаг, БНСУ-ын “BK Holdings”, “MAP”, “Шин Тай Ян констракшн” зэрэг томоохон групп компаниудтай хамтран ажиллах санамж бичгийг үзэглэлээ.

GIZ-ийн PROGRES төсөл тус форумыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран зохион байгуулагчаар оролцсон юм.



ОРХОН АЙМГИЙН ЖДҮ НАРЫН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ



GIZ-ийн “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих” (PROGRES) болон GIZ-ийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” (сTVET) төслүүд, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Орхон аймгийн Худалдаа, Аж Үйлдвэрийн танхим хамтран 2023 оны 6-р сарын 14-ний өдөр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх танилцуулах уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтаар “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн төлөөлөл, PROGRES төслийн бизнесийн сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан жижиг дунд бизнес эрхлэгчдэд гагнуурын сургалт, дадлагын анги танхим, тоног төхөөрөмжүүд, ур чадварыг хөгжүүлэх боломжуудыг танилцуулав.

GIZ-ийн сTVET төсөл нь тус сургуулийн гагнуурын мэргэжлийн багш нарыг чадавхжуулж, анги танхимыг тохижуулан нийт 240,000 Еврогийн өртөг бүхий төрөл бүрийн тоног төхөөрөмж олгожээ.

Цаашид “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Орхон аймгийн Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимтай хамтран орон нутгийн ЖДҮ нарын гагнуурын ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэлэлцэж байна.

Энэхүү ажил нь GIZ-ийн төслүүдийн Орхон аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж буй хамтын хувь нэмэр юм.



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН АХИСАН ТҮВШНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖЛЭЭ

“Гүйцэтгэх удирдлагын ахисан түвшний хөтөлбөр” Орхон аймагт амжилттай хэрэгжлээ. Гурван сарын турш хэрэгжсэн энэхүү хөтөлбөрөөр гүйцэтгэх удирдлагад тулгарч байгаа асуудлуудыг хамтран шийдэхдээ бүтээлч байх, гүйцэтгэл өндөртэй багийг бүрдүүлэх, багийн сахилга батыг хангах сүүлийн үеийн арга, аргачлалд оролцогчдыг сургав.

Сургалтын явцад оролцогчид 4 баг бүрдүүлж, тодорхой зорилт тавин түүндээ хэрхэн хүрэх, сургалт зөвлөх үйлчилгээнээс сурсан мэдлэгээ хэрхэн

хэрэгжүүлэх, өөрийн туршлага, мэдлэгээ бусадтай хуваалцан хамтран дадлагын ажил гүйцэтгэсэн юм. Хөтөлбөрийн сүүлийн шатанд төслийн зөвлөх багш нар багуудын дунд сургалтын сэдвүүдээр уралдаан зарлаж “Eagle” баг тэргүүн байр эзлэв.


Хөтөлбөрт оролцогчдын санаачилгаар “Super CEO” клуб байгуулж, хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэх болжээ.



ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТООН ХЭЛЭЭР


PROGRES төслийн 2-р бүрэлдэхүүн хэсэг 2023 оны эхний хагас жилд ЖДҮ-г дэмжсэн 106 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийтдээ 1373 бизнес эрхлэгчдэд хүрч ажиллажээ.

Арга хэмжээний тоо, аймгаар 2023



Төслийн сургалт зөвлөх үйлчилгээнд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь харвал, 25,8 хувь нь үйлчилгээний, 21.8 хувь нь үйлдвэрлэлийн, 18.1 хувь нь хөдөө аж ахуйн, 17.1 хувь нь худалдааны, 8 хувь нь барилгын, 8.5 хувь нь бусад салбарт ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл, хувиар



Төслийн зорилтот аймгуудад ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээнд нийцсэн 12 дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. Үүнээс **9 дэд** хөтөлбөрийн хүрээнд чадавхиж буй ЖДҮ эрхлэгчдийн дунд бизнесийн уралдааныг зарлан **35 ЖДҮ-д** аж ахуйн нэгжид **234.000.000** төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалгүй дэмжлэг олголоо.

“БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ БА АЖИЛТНЫ ХАНДЛАГА ЗАН ҮЙЛ” СУРГАЛТ

GIZ PROGRES төсөл нь 2022 онд Хүний нөөцийн менежментийн чиглэлээр компанийн удирдлага, менежерүүдийг чадавхжуулсан.

Эдгээр сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтан албан хаагчдын зан үйл, оролцоог хангах, улмаар байгууллага аж ахуйн нэгжийн бүтээмж, тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор 2023 онд Хүний нөөцийн менежментийг сургалтуудыг байгууллагын нийт албан хаагч, ажилтнуудад чиглэн зохион байгуулж ирлээ.

Одоогийн байдлаар энэхүү “Байгууллагын соёл ба ажилтны хандлага зан үйл” сургалтуудыг Орхон, Ховд аймгуудад зохион байгуулж 12 ЖДҮ нарын 100 орчим ажилтан хамрагдаад байна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЦУВРАЛ СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.



Жижиг, дунд компаниудын Гүйцэтгэх удирдлага болон хүний нөөц хариуцсан менежерүүдэд зориулсан “Стратегийг дэмжсэн хүний нөөцийн менежмент” цуврал сургалтыг 2023 оны 3-р сараас эхлэн Улаанбаатар хотод зохион байгуулж байна. Үүний зэрэгцээ оролцогчид сургалтын сэдвээр өөрийн компанийн байранд ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг авах боломжтой юм.

“Нийслэлийн жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-тай хамтран зохион байгуулж байгаа энэхүү цуврал сургалтад 15 ЖДҮ -ийн төлөөлөл оролцож байна.

Сургалт нь компанийн стратеги ба хүний нөөцийн менежмент, байгууллагын соёл, ажилтны хандлага, чадамжид суурилсан сонгон шалгаруулалт, чадамжид суурилсан албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн удирдлага – KPI, хөдөлмөрийн харилцааны хууль эрх зүй гэсэн агуулгыг хамарч байгаа юм.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЭЭЛЖИТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулахад GIZ-PROGRES төслийн зүгээс дэмжин ажиллалаа.

Тус хэлэлцүүлэг нь өнгөрсөн 2 сарын хугацаанд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтээс ирүүлсэн санал болон хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй хийсэн цуврал уулзалт, хэлэлцүүлгүүдийн үеэр өгсөн санал, хүсэлтийг хуулийн төсөлд тусгасан талаар танилцуулснаараа онцлог боллоо.

Хуулийн төсөлд олон улсын байгууллага, хөгжлийн түншүүд, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг ирүүлсэн байна.

Хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн олон нийтийн саналуудыг хэрхэн тусгасан талаар эргэн танилцуулж, хөрөнгө оруулагч, бизнесийн байгууллагуудынхаа оролцоог ханган ажиллаж байгааг онцлон тэмдэглэлээ.



ХОНЬ ХЯРГАХ ДАДЛЫГ САЙЖРУУЛАХ

GIZ-PROGRES төсөл нь ноосны салбарыг дэмжих зорилгоор Share Mongolia төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Монгол Улсад хонь хяргах ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор энэ оны эхээр хонь хяргихад ашиглах чиргүүлийг PROGRES-ээс санхүүжүүлсэн. 6-р сард Share Mongolia компани малчдад зориулан Монголын зарим газруудад таван удаа чиргүүл ашиглан үзүүлэх сургалт зохион байгуулж байна. Шинэ Зеландын хонь хяргах 14 мэргэжилтэн сайн дураараа Шинэ Зеландын фермүүд дээр өдөрт 200 гаруй хонь хяргахаар бэлтгэгдсэн хэсэг малчдын хамт үзүүлэх сургалт зохион байгуулж байна.





**Нэг хүн гараараа
өдөржин хэрчдэг
байсан хүнсний
ногоог 30
минутын дотор
нэгэн жигд
хэрчдэг болсноор
хөдөлмөрийн
бүтээмж 16 дахин
дээшилсэн.**

А.ЭНЭРЭЛ

Ховд аймгийн “Баяр хөөр түгээсэн ургац” хоршооны менежер

Манай хоршоо PROGRES төслийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөрүүдэд амжилттай оролцлоо. Дээрх хөтөлбөрүүдэд хамрагдсанаар бизнесээ эрхлэхэд хоршооны менежерийн хувьд өөрийгөө, гишүүдээ тасралтгүй хөгжүүлэх шаардлагатайг ойлгож авлаа.

Манай хоршоо нь хүнсний ногоог олон нэр төрлөөр даршлан, зах зээлд нийлүүлдэг. Бид “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах” хөтөлбөрийн бизнесийн уралдаанд шалгарч, ногоо хэрчигч тоног төхөөрөмжтэй болсон. Нэг хүн гараараа өдөржин хэрчдэг байсан хүнсний ногоог 30 минутын дотор нэгэн жигд хэрчдэг болсноор хөдөлмөрийн бүтээмж 16 дахин дээшилсэн юм.

Орон нутагтаа брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор бид “УРГАЦ АГРО” брэндийг үүсгэн ажиллаж байна. Хөдөө орон нутагт бизнес эрхлэгчдэд нэн шаардлагатай бизнесийн сургалт зөвлөх үйлчилгээг үзүүлж байгаа төслийн хамт олон, зөвлөх багш нартаа баярлалаа. Мөн төслийн бизнесийн уралдааны сонгон шалгаруулалт маш шударга явагддаг гэдгийг хэлэхэд таатай байна.



**Манай хоршоо
орон нутгийн
томоохон
худалдан авагч
болох уул
уурхайн “Мон Эн
Ко” компанийн
ханган
нийлүүлэгч болж
чадлаа.**



Г.АЛТАНЦЭЦЭГ

**Ховд аймгийн Дарви
сумын “Баялаг сутайн
хөгжил” хоршооны
дарга**

“Брэндинг ба хууль эрх зүй” гэсэн сургалт нь “Арвайтай цайгаа Ховд, тэр дундаа Дарви сумаараа овоглосон брэнд бүтээгдэхүүн болгох юм сан” гэсэн миний хүсэл мөрөөдөлд минь маш ихээр нийцэж байсан учир тус хөтөлбөрт оролцохоор шийдвэрлэсэн юм.

Улмаар 2022-2023 онуудад брэндийн сургалт зөвлөх үйлчилгээнд хамрагдаж, өөрийн бүтээгдэхүүнээ хөгжүүллээ. Бизнесийн уралдаанд оролцож, шилдэг бүтээгдэхүүнээр шалгарч, савлагааны тоног төхөөрөмжтэй болсноор Арвайтай цайныхаа сав баглаа боодлоо шинэчлэв.

Үүний үр дүнд манай хоршоо орон нутгийн томоохон худалдан авагч болох уул уурхайн “Мон Эн Ко” компанийн ханган нийлүүлэгч болж чадлаа. Энэ амжилт маань PROGRES төслөөс зохион байгуулж буй сургалт зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмжийн тэтгэлэгтэй салшгүй холбоотой гэж боддог.



ЖДҮ эрхлэгчдийн сэтгэгдлээс



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих дэд хөтөлбөрт хамрагдсанаар шинээр катеринг үйлчилгээ нэмж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Д. БЯМБААХҮҮ

Орхон аймгийн “Анир ялдам” ХХК-ийн үүсгэн байгуулагч


“Анир ялдам” ХХК нь бизнес модель, брэндинг, хүний нөөцийн цогц сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдан суралцаж, ажилтнууддаа эерэг хандлага, байгууллагадаа том өөрчлөлтийг авчирч чадлаа.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих дэд хөтөлбөрийн бизнесийн уралдаанд оролцон шалгарч, тоног төхөөрөмжийн дэмжлэг авснаар шинээр катеринг үйлчилгээ нэмж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Орхон аймгийн ЖДҮ эрхлэгчдийг чадавхжуулах төрөл бүрийн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, тоног төхөөрөмжийн дэмжлэг олгож, ковид цар тахлын дараах хүндрэлийг даван туулахад үнэлж барамгүй тус нэмэр болж буй төслийн багийн хамт олон, зөвлөх багш нартаа талархаж байна.



ЖДҮ эрхлэгчдийн сэтгэгдлээс



Б. ЦЭВЭЛМАА

Орхон аймгийн “Cara care” Брэндийг үүсгэн байгуулагч

2022 оноос “Үлэмж нандин” ХХК -г байгуулж охидын “CARA CARE” брэндийг бий болгон ажиллаж байна.

Брэндээ зөв эхлүүлж, хөгжүүлэхийн тулд “Брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт хамрагдсан. 2023 онд бизнесийн уралдаанд амжилттай оролцон тоног төхөөрөмжийн буцалтгүй дэмжлэг авснаар бүтээгдэхүүний чанар сайжирч, бүтээмж нэмэгдэн, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнүүд нэмж үйлдвэрлэж байна.

Ингэсээр “CARA CARE” брэнд маань эх нярайн BORODO дэлгүүрт бүтээгдэхүүнээ нийлүүлж эхэлсэн бөгөөд Орхон аймагт зохион байгуулж буй үзэсгэлэн худалдаануудад төслийн дэмжлэгтэйгээр оролцож байнгын үйлчлүүлэгчдийнхээ тоог нэмсээр байна.

**“CARA CARE”
брэнд маань эх
нярайн BORODO
дэлгүүрт
бүтээгдэхүүнээ
нийлүүлж
эхэлсэн**



БИЗНЕС ХӨГЖЛИЙН ТӨВ

Д. ЁНДОНЖАМЦ

Ахлах мэргэжилтэн, Улаанбаатар

Улаанбаатар хот, 210646,
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо НҮБ-
ын гудамж, 38-р байр, 1-р давхар
E: demid.yondonjamts@giz.de
T: 976-9903 5373

Г. АЗЗАЯА

Мэргэжилтэн, Орхон аймаг

Баян-Өндөр сум, Эрдэнэт хот,
Бүрэн бүст баг
5-р микро 7а байр, 2-р давхар
E: galsanmolom.azzaya@giz.de
T: 976-9935 5809

Т. ЭРДЭНЭЦЭЦЭГ

Мэргэжилтэн, Ховд аймаг

Жаргалант сум, Бичигт баг,
Найрамдал 4-р гурамж
403-байр, 2-р давхар
E: tumurbaatar.erdenetsetseg@giz.de
T: 976-9908 1378

